



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 05 сарын 09 өдөр

Дугаар А/92

Улаанбаатар хот

**Сонгинохайрхан дүүргийн 106 дугаар
сургуулийн эргэлтийн бус хөрөнгийг
данснаас хасах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2019 оны 5 дүгээр сарын 02-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй хавсралтад заасан 80,000,000 /наян сая/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий эд хөрөнгийг данс бүртгэлээсээ хасахыг Сонгинохайрхан дүүргийн 106 дугаар сургууль /П.Энхчимэг/ -д зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй 1 нэр төрлийн 80,000,000 /наян сая/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг Өмчийн харилцааны газарт актаар хүлээлгэн өгч, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийхийг Сонгинохайрхан дүүргийн 106 дугаар сургууль /П.Энхчимэг/ -д үүрэг болгосугай.

3. Татан төвлөрүүлж буй хөрөнгийг үнэлж, худалдан борлуулах ажлыг зохион байгуулахыг Өмчийн мэдээлэл, хяналт, ашиглалтын хэлтэс /Н.Раднаасэд/-т, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн төлөөлөл, менежментийн хэлтэс /М.Энхболд/-т даалгасугай.


ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ



Ч.ОДНАСАН

115050009355

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын
газрын даргын 2019 оны 05 сарын
09 өдрийн А/9 дугаар тушаалын хавсралт



Данснаас хасах эргэлтийн бус хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Сонгинохайрхан дүүргийн 106 дугаар сургууль

/төгрөгөөр/

Д/д	Эд хөрөнгийн нэр	Ашигласан жил	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг /2019.03.31-ний байдлаар/	Эвдрэл гэмтэл	ӨХБЗ-ийн дүгнэлт	ЭБХХК-ийн хурлын шийдвэр
1	Уурын зуух /халаалтын тогоо/	5	ш	2	40,000,000.0	80,000,000.00	28,444,444.16	51,555,555.84	төвлөрсөн дулааны шугамд холбогдож, ашиглалтгүй болсон	татан төвлөрүүлэх	
Нийт дүн						80,000,000.00	28,444,444	51,555,555.84			
Үүнээс :											
Акталж устгах хөрөнгийн дүн											
Татан төвлөрүүлэх хөрөнгийн дүн						80,000,000.00					